



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 43

Мандалговь

**Хөрөнгө шилжүүлэх тухай.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31, 77 дугаар зүйлийн 77.3, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 сарын 15-ны өдрийн 32 тоот тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа хавсралтад дурдагдсан 991.692 төгрөгийн үнэ бүхий 1ш компьютерийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооний өмчлөлд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад бүртгэгдсэн өмч хөрөнгийг данснаас хасахыг Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс /Н.Ганбаяр/-д, холбогдох хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийг бүртгэн авч эзэмшихийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо /Х.Эрдэнээ/-д үүрэг болгосугай.



ДАРГА  С.БУДЖАВ